

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дэлгэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/06/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhanda@audit.gov.mn Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 03. 25 № 127

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 37.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн малын хөлийн албан татварын төлөвлөгөөг 35.4 сая төгрөгөөр тасарсан, малын тоо, толгойн албан татварын орлого 66.6 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй зэрэг нийт 139.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, Дэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 49 дүгээр тогтоолын нэг дэх заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдрийн 10/683 дугаар тоот албан бичгийн хавсралтаар Төсвийн тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийг хүргүүлжээ.

Аудитын гол асуудал

0702900403

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны зардлын нийт гүйцэтгэл өмнөх оноос 860.1 сая төгрөг буюу 55.0 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь урсгал зардал буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 117 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 93.7 хувийн биелэлттэй гаргаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 93.7 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	607,244.9	703,481.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,166,976.2	4,777,614.7
	Нийт хөрөнгийн дүн	1,774,221.1	5,481,095.7
	Нийт өр төлбөрийн дүн	4,617.6	18,858.1
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,769,603.5	5,462,237.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,774,221.1	5,481,095.7
Үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,427,002.6	4,880,578.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,910,959.1	1,050,851.6
	Үйл ажиллагааны үр дүн	516,043.5	3,829,726.6
	Үйл ажиллагааны бус үр дүн	2,659,691.0	134,581.3
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(2,143,647.5)	3,695,145.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,913,251.0	1,769,603.5
	НББ-ын өөрчлөлт	(175,370.3)	(2,511.2)
	Тайлант оны үр дүн	(2,143,647.5)	3,695,145.2
	Эцсийн үлдэгдэл	1,769,603.5	5,462,237.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,252,314.8	1,557,463.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,834,195.3	897,081.8
	Үйл ажиллагааны ЦМГ	418,119.6	660,382.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(346,032.4)	(533,705.2)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(14,000.0)	(56,000.0)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	58,087.1	70,676.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	173,553.2	231,640.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	231,640.3	302,317.3
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,525,718.3	1,259,171.4
	Урсгал зардал	968,809.5	885,813.3
	Хөрөнгийн зардал	433,758.8	317,358.1
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,166,309.5	980,591.4
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	200,858.8	194,833.0
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	158,550.0	63,559.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2,550.0	62,087.8
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	55,000.0	1,471.5
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,000.0	-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	106,100.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	85,912.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	980,591.4

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,533,439.2 мянган төгрөгийн 4 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.

Аудитаар нийт 139,947.4 мянган төгрөгийн 9 зөрчил илрүүлснээс, 87,321.5 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 52,625.9 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлсэн байна.

Залруулагдаагүй зөрчлийн дүн 139,947.4 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 30,514.4 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

байна.

Аудитаар нийт 139,947.4 мянган төгрөгийн 9 зөрчил илрүүлснээс, 87.3 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 52,625.9 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлсэн байна.

Залруулагдаагүй зөрчлийн дүн 139,947.4 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 30,514.4 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар нийт 31,993.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 18,711.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 13,281.5 төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагыг 1,530,334.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 1 алдааг залруулж, 5,954.2 төгрөгийн 3 зөрчил илрүүлж, 1,971.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 3,983.2 төгрөгийн 1 зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

3.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 102,000.0 мянган төгрөгийн 2 зөрчил илрүүлснээс 66,638.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 35,361.2 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж байна.

3.1 Төлбөрийн акт

1.Малын тоо, толгойн албан татварын орлого 66,638.8 мянган төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй малын хөлийн албан татварыг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг тулган баталгаажуулахад малын хөлийн албан татвар 35,361.2 мянган төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2.Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 37,947.4 төгрөгийн зөрчил илэрч, 20,682.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 17,264.7 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ

өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Дэлгэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газар	1	1,530,334.0	-	-	1	1,530,334.0	1	1,530,334.0	-	-	-	-
Дэлгэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	3	3,105.2	-	-	3	3,105.2	3	3,105.2	-	-	-	-
Дүн	4	1,533,439.2	-	-	4	1,533,439.2	4	1,533,439.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Дэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	2	102,000.0	1	66,638.8	1	35,361.2	-	-	-	-	-	-
Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газар	3	5,954.2	2	1,971.0	1	3,983.2	-	-	-	-	-	-
Дэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	342.3	-	-	1	342.3	-	-	-	-	-	-
Дэлгэр сумын Орон нутгийн хөгжлийн сан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэр сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	3	31,650.9	1	18,711.7	2	12,939.2	-	-	-	-	-	-
Дүн	9	139,947.4	4	87,321.5	5	52,625.9	-	-	-	-	-	-

Дэлгэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ	-	-	-	-	-	-	-	-
ОНХС	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ	-	-	-	-	-	-	-	-
ИТХ	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1	-		-	1	-	-
2	Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газар	1	1			1			
3	Дэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
4	Дэлгэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Дэлгэр сумын Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
6	Дэлгэр сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1		1					
	НИЙТ	6	2	4		1	1		

Дэлгэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан